



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 312

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 3.2 дахь хэсгийн заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 5.6, 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Сангийн яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 58,000,000.00 (тавин найман сая) төгрөгийн балансын үнэ, 41,083,333.05 (дөчин нэгэн сая наян гурван мянга гурван зуун зучин гурван төгрөг таван мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг Гадаад харилцааны яаманд балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Наранцогт, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Анхбаяр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д оруулан бүртгэх;

2.3. Автомашины улсын дугаарыг шилжүүлсэн тодорхойлолт, арга хэмжээний биелэлтийг 2021 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс /Д.Нарангэрэл/-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого,
зохицуулалтын газрын 2021 оны 07
дугаар сарын 08-ний өдрийн 312
дугаар тогтоолын хавсралт

**Сангийн яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй Гадаад харилцааны яамны
балансад шилжүүлэх үндсэн хөрөнгийн жагсаалт**

№	Хөрөнгийн нэр	Ашиглал тад орсон он	тоо шир хэг	Балансын үнэ/төгрөг/	Хуримтлагдсан элэгдэл/төгрөг/	Үлдэгдэл өртөг /төгрөг/
1	Хьюндай азера маркийн 0551 УБҮ улсын дугаартай, суудлын автомашин, арлын дугаар КМНГН41НВЕА364505	2014	1	58,000,000.00	41,083,333.05	16,916,666.95
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		1 (нэг)	58,000,000.00 (тавин найман сая)	41,083,333.05 (дөчин нэгэн сая наян гурван мянга гурван зуун зучин гурван төгрөг таван мөнгө)	16,916,666.95 (арван зургаан сая сөн зуун арван зургаан мянга зургаан зуун жаран зургаан төгрөг ерэн таван мөнгө)